



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/68

Есөнбулаг

Газрын байршил өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан Алтай хотын Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө (2015-2030 он)-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. "Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөний тодотгол"-д тусгагдсаны дагуу аймгийн Сум дундын ойн анги (3248585)-ийн аймгийн Засаг даргын 2020 оны А/68 дугаар захирамжаар Мод үржүүлгийн газар (4104)-ын зориулалтаар 8208005048 дугаар нэгж талбарт эзэмшиж байгаа газрын байршлыг өөрчлөн хавсралтаар баталж, 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшсэн аймгийн Сум дундын ойн ангийн мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн баталгаажуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

3. Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/68 дугаар захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА




О.АМГАЛАНБААТАР

**СУМ ДУНДЫН ОЙН АНГИ (3248585) - ИЙН
ЭЗЭМШИХ ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ**

Нэгж талбарын дугаар: 620800...

Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Индэрт баг



2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн
Анхны дугаар захирагчийн /.../ р хавсралт

Огноо: 2023-08-25

Хашааны координат:

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5137277.232	290317.016	50.00	1-2
2	5137256.519	290295.314	45.00	2-3
3	5137289.073	290264.245	30.00	3-4
4	5137309.766	290285.947	45.00	4-1

Талбайн хэмжээ: 1350.0 квадрат метр

Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)